



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/129

Сүхбаатар сум

Улсын бүртгэлийн хууль тогтоомж сурталчлах,
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Нэг иргэн-нэг бүртгэл" үндэсний хөтөлбөр батлах тухай 144 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх" үндэсний хөтөлбөр батлах тухай 50 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны "Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх" аймгийн хөтөлбөр батлах тухай 154 дүгээр тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний 8.1, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.7 дахь зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын бүртгэлийн ажил үйлчилгээний шуурхай бэлэн байдлыг хангаж, бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх зорилтын хүрээнд бүх сумдыг улсын бүртгэлийн онлайн мэдээллийн сүлжээнд холбосх бэлтгэл ажлыг хангах, шинээр батлагдсан Улсын бүртгэлийн багц хуулиуд болон "Нэг иргэн-нэг бүртгэл" үндэсний болон аймгийн хөтөлбөрийг иргэдэд сурталчлах тараах материал бэлдэх тооцоог нэгдүгээр, сумдаар явах шатахууны тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, аймгийн хэмжээнд зохион байгуулахыг Улсын бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Саранчимэг/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/ нарт даалгасугай.

2. Онлайн сүлжээнд холбох бэлтгэл ажлыг хангах, хууль, тогтоомж хөтөлбөрүүдийг сурталчлах ажлыг зохион байгуулахад шаардагдах 1.500.000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Зардлын тайланг 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор гаргаж тайлагнахыг Улсын бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Саранчимэг/-т даалгасугай.

4. Онлайн сүлжээнд холбох бэлтгэл ажлыг хангах, хууль тогтоомж болон хөтөлбөрүүдийг сурталчлах ажлыг үр дүнтэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ